

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2024 оны 05 дугаар сар

АГУУЛГА:

1. ДНБ
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр
10. Гадаад эдийн засаг – ОХУ, БНХАУ



ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ-ий өсөлт

(2024 оны 1 дүгээр улирал)

7.8 хувь

Валютын нөөц

(2024 оны 5 дугаар сар)

5,183 сая \$

Инфляц

(2024 оны 5 дугаар сар)

5.7 хувь

Төсвийн тэнцэл

(2024 оны 5 дугаар сар)

2.0 их наяд ₮

Экспорт

(2024 оны 5 дугаар сар)

6,356 сая \$

Импорт

(2024 оны 5 дугаар сар)

4,395 сая \$

ГШХО

(2024 оны 1 дүгээр улирал)

885 сая \$

Зээлийн хүү

(2024 оны 5 дугаар сар)

16.9 хувь

Ажилчдын тоо

(2024 оны 1 дүгээр улирал)

1.3 сая

*1 улирлын байдлаар ажиллах хүчний оралцооны түвшин 60 хувь байна.

Бодит цалингийн өсөлт

(2023 оны 4 дүгээр улирал)

16.4 хувь

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2024 оны 1 дүгээр улирал)

97.8 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт

(2024 оны 1 дүгээр улирал)


19.8 хувь



2024 оны эхний улиралд эдийн засгийн өсөлт 7.8 хувь байсан бол эхний 4 сарын байдлаар 6.1 хувь байна. Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйгаас бусад салбарын үйлдвэрлэл эерэг нөлөө үзүүлсэн хэвээр байна. Өмнөх оны өндөр суурийн нөлөөгөөр уул уурхайн салбарын оролцоо багасаж, үйлчилгээний салбар эдийн засгийн өсөлтийг тэтгэж байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Тайлбар: 2024.3 сарын туршилт тооцоо

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ


(2024 оны 3 дугаар сар)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УУЛ УУРХАЙ


(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХӨДӨӨ АЖ АХУЙ

(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Бодит ДНБ 2024 оны эхний улиралд **7.8 хувиар өслөө.**
- Анхдагч салбар: Уул уурхайн салбар 13.1 хувиар тэлж өсөлтийн 1.9 хувийг, ХАА-н салбар 31.4 хувиар буурч өсөлтийг -1.3 хувиар хязгаарлалаа.
- Хоёрдогч салбар /боловсруулах, барилга, цахилгаан, усан хангамж/-ын үйлдвэрлэл 8.5 хувиар өсөж өсөлтийн 0.9 нэгж хувийг;
- Үйлчилгээний салбар /худалдаа, тээвэр, үйлчилгээний бусад/ 7.7 хувиар өсөж өсөлтийн 4.1 хувийг ;
- Бүтээгдэхүүний цэвэр татвар 13.1 хувиар өсөж өсөлтийн 2.1 хувийг бүрдүүлсэн байна.

- Үйлчилгээний салбар болон цэвэр татварын орлого нэмэгдсэнээр өсөлтийн дийлэнхийг бүрдүүлж байна. Мөн боловсруулах, барилгын салбарын үйлдвэрлэл өсөлттэй байв.
- Харин том малын зүй бус хоргодол нэмэгдэж, хөдөө аж ахуйн салбар агшив.

- Уул уурхайн салбар 2024 оны эхний улиралд 13.1 хувиар тэллээ.
- Газрын тос, молибдений баяжмал, алтны олборлолтоос бусад уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн олборлолт нэмэгдсэнээр уул уурхайн салбарын үйлдвэрлэлд эергээр нөлөөллөө.


- ХАА-н салбар 2024 оны эхний 3 сард 31.4 хувиар агшлаа.
- Том малын зүй бус хоргодол 2024 оны 1 дүгээр улиралд 6.3 сая толгойд хүрч өмнөх оны мөн үеэс 5.4 сая толгой малаар нэмэгдлээ. Энэ нь оны эхний нийт малын 9.8 хувийг эзэлснээр хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл жил дараалан буурч байна.



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны эхний 5 сарын байдлаар 16 хувиар өсөв. Нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдрийн олборлолт уул уурхайн салбарын үйлдвэрлэлд эергээр нөлөөлж байгаа бол хөнгөн болон хүнд үйлдвэрлэл боловсруулах салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж байна.

НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ

(тэрбум төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2024 оны эхний 5 сарын байдлаар 12.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.7 их наяд буюу 16 хувиар өслөө.
- Нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдэж, уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 18 хувиар нэмэгдээд байна.
- Хөнгөн болон хүнд үйлдвэрлэл нэмэгдэж, боловсруулах салбарын үйлдвэрлэл 11 хувиар өслөө.

БОДИТ ҮЙЛДВЭРЛЭЛ

(өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, тооцоолол

- Тус салбарын бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн индексээр засварласан) 2024 оны эхний 5 сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.8 хувиар өсөөд байна. Үүнд:
- Салбарын дийлэнхийг эзэлдэг уул уурхайн салбарын үйлдвэрлэл 16.4 хувиар өсөж, бодит өсөлтийн 10.0 нэгж хувийг бүрдүүлэв.
- Харин боловсруулах, цахилгаан, усан хангамжийн салбаруудын үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс тус тус 2.4 хувь, 0.7 хувь, 13.5 хувиар өссөн байна.

УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ


(голлох бүтээгдэхүүнээр)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Нүүрс олборлолт 2024 оны эхний 5 сард 39 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 30 хувиар нэмэгдээд байна.
- Төмрийн хүдэр, баяжмал олборлолт өмнөх оны мөн үеэс сэргэж 59 хувиар өсөв.
- Зэсийн баяжмал үйлдвэрлэл 5 хувиар өсөж 612 мянган тоннд хүрсэн байна.
- Харин алт болон газрын тос олборлолт өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн түвшнээс буурсан хэвээр байна.

ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС (2015=100)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Үйлдвэрлэгчийн үнийн индекс өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар, цар тахлын өмнөх үеэс 71.9 хувиар өслөө. Үнийн индексийг бүрэлдэхүүнээр харвал:

Үнэ өссөн:

- Хүнсний бүтээгдэхүүн 12.5 хувиар,
- Ундаа, согтууруулах ундаа 11.4 хувиар,
- Нэхмэлийн үйлдвэрлэлийнх 9.5 хувиар тус тус өссөн бол

Үнэ буурсан:


- Арьс, арьсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийнх 1.9 хувиар,
- Цахилгаан тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийнх 2.8 хувиар тус тус буурулаа.



Дотоод эрэлт идэвхжиж, эдийн засгийн өсөлт эрчимжив.

ДНБ ӨСӨЛТИЙН БҮТЭЦ


(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ТӨРИЙН БОЛОН ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ӨСӨЛТ


(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХӨРӨНГИЙН ХУРИМТЛАЛЫН БҮТЭЦ


(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ

(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Эрэлтээс тооцсон ДНБ 2024 оны эхний улиралд 7.8 хувиар өслөө.
- Өсөлтөд эцсийн хэрэглээ 23.4 нэгж хувийн, хөрөнгийн хуримтлал 3.8 нэгж хувийн тус тус зэрэг нөлөө, цэвэр экспорт 19.4 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлэв.

- Тэтгэвэр, тэтгэмж, төрийн албан хаагчдын цалинг нэмсэнтэй холбоотойгоор төрийн хэрэглээ өмнөх оны мөн үеэс 47.1 хувиар өсөж, нийт эрэлтийг дэмжиж байна.
- Өрхийн бодит орлого 19.8 хувиар сайжирсан нь нийт өрхийн хэрэглээг дэмжиж, өмнөх оны мөн үеэс 20.1 хувиар тэлэв.


- Үндсэн хөрөнгийн хуримтлал 5.4 хувиар агшлаа.
- Том малын зүй бус хорогдол 6.3 сая толгойд хүрсэн нь эдийн засаг дах үндсэн хөрөнгийн хуримтлал буурахад голлон нөлөөллөө.

- Үйлчилгээний экспортын орлого өмнөх оны мөн үеэс багасаж, нүүрс, зэсийн баяжмалын үнийн бууралтаас шалтгаалан бараа, үйлчилгээний экспорт 2024 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар буурав.
- Бараа, үйлчилгээний импорт өмнөх оны мөн үеэс 10.8 хувиар өсөхөд барааны импорт 24.4 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.




Гадаад худалдааны тэнцэл 2024 оны эхний 5 сарын байдлаар 1,961 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 31.0 хувиар буурлаа.

ЭКСПОРТ (сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ (сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ИМПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Экспорт 2024 оны эхний 5 сард 6,356 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 1 хувиар өслөө.
- Нийт экспортын 95 хувийг уул уурхай бүтээгдэхүүн, тэр дундаа нүүрсний экспорт дангаараа 60 хувийг бүрдүүлж байна.

- Нүүрсний экспортын орлого 3,817 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар өслөө.
- Зэсийн баямалын экспортын орлого 1,151 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 5 хувиар өслөө.
- Алтны экспортын орлого 333 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 13.5 хувиар өслөө.
- Төмрийн хүдрийн экспортын орлого 237 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 21.5 хувиар өслөө.

- 2024 оны эхний 5 сард импорт 4,395 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 27 хувиар өссөн байна.
- Нийт импортын 19.1 хувийг тоног төхөөрөмж, 18.8 хувийг нефть, 8.7 хувийг автомашин эзэлж байна.


- Тоног төхөөрөмжийн импорт 840 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 44.8 хувиар өслөө.
- Нефтийн бүтээгдэхүүний импорт 826 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 28.4 хувиар өслөө.
- Суудлын автомашины импорт 383 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 52.4 хувиар өслөө.



2024 оны эхний 5 сарын байдлаар уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 95 хувийг, тэр дундаа нүүрс болон зэсийн баяжмал дангаараа 80 хувийг бүрдүүллээ.

НҮҮРС


(сая тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЗЭСИЙН БАЯМЖАЛ


(тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ТӨМРИЙН ХҮДЭР


(мян. тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГАЗРЫН ТОС

(мян. баррель)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Нүүрсний экспорт 2024 оны 5 дүгээр сард 7.2 сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 80 хувиар өслөө.
- Гашуунсухайт боомтоор 3.6 сая тонн, Шивээхүрэн боомтоор 2.2 сая тонн, Ханги боомтоор 0.7 сая тонн, бусад боомтуудаар 0.7 сая тонн нүүрс тус тус экспортолсон байна.

- Зэсийн баяжмалын экспорт 2024 оны 5 дүгээр сард 144 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 2.2 хувиар буурлаа.
- Гашуунсухайт боомтоор 89 мянган тонн, Замын-Үүд боомтоор 54 мянган тонн зэсийн баяжмал тус тус экспортолсон байна.


- Төмрийн хүдрийн экспорт 2024 оны 4 дүгээр сард 592 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 21.2 хувиар өслөө.
- Замын-Үүд боомтоор 520 мянган тонн, Бургастай боомтоор 60 мянган тонн, бусад боомтуудаар 12 мянган тонн төмрийн хүдэр тус тус экспортолсон байна.

- Газрын тосны экспорт 2024 оны 5 дүгээр сард 347 мянган баррельд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 16.4 хувиар буурлаа.
- Баянхошуу боомтоор 313 мянган баррель, Замын-Үүд боомтоор 34 мянган баррель газрын тос тус тус экспортолсон байна.




2024 оны эхний 5 сарын байдлаар сарын ноолуураас бусад голлох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт өмнөх оны мөн үеэс буурлаа.

МАЛЫН МАХ (тонн)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

БОЛОВСРУУЛСАН АРЬС ШИР (мянган дм квадрат)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

НООЛУУР (тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

НООС (тонн)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Малын махны экспорт 2024 оны эхний 5 сард 17,276 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 52 хувиар буурлаа.
- Тэр дундаа боловсруулсан махны экспорт өмнөх оны мөн үеэс 3 дахин багасаж 6,615 мянган тоннд хүрлээ.
- Боловсруулсан арьс ширний экспорт 2024 оны эхний 5 сард 39,124 мянган дм квадратад хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 31 хувиар буурлаа.
- Ноолуурын экспорт 2024 оны эхний 5 сард 1,327 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 9 хувиар өслөө.
- Ноосны экспорт 2024 оны эхний 5 сард 111 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 45 хувиар буурлаа.



ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ
ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА






2024 оны эхний 5 сарын байдлаар УУББ-ээр нийт 28 сая тонн нүүрс болон 1.5 сая тонн төмрийн хүдэр болон баяжмал, 5.4 мянган тонн зэсийн баяжмалыг арилжаалаад байна.

НҮҮРСНИЙ АРИЛЖАА

(сая тонн)




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2024 оны 5 дугаар сарын байдлаар 2023 оноос хойш нийт 28 сая тонн нүүрс арилжиж, 3.8 тэрбум ам.долларын орлого олжээ.
- 2024 оны 5 дугаар сарын байдлаар 2024 онд 13.3 сая тонн нүүрс арилжиж, 1.6 тэрбум ам.долларын орлого олжээ.
- 2024 оны 4 дүгээр сард 4.2 сая тонн нүүрс борлуулсан бол 5 дугаар сард 3.9 сая тонн нүүрс борлууллаа.

НҮҮРСНИЙ ДУНДАЖ ҮНЭ

(ам.доллар/тонн)




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 5 дугаар сард нүүрсний дуудах дундаж үнэ 103 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 112 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 5 дугаар сард хэлцлийн доод үнэ 52 ам.доллар, дээд үнэ 172 ам.долларт хүрэв.

ТӨМРИЙН АРИЛЖАА

(мянган тонн)




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2024 оны 5 дугаар сарын байдлаар 2023 оны 9 дүгээр сараас хойш нийт 1.5 сая тонн төмрийн хүдэр, баяжмалыг 117 сая ам.доллаароор борлууллаа.
- 2024 оны 5 дугаар сарын байдлаар 2024 онд 813 мянган тонн төмрийг арилжаалж, 60 сая ам.долларын орлого олжээ.

ТӨМРИЙН ДУНДАЖ ҮНЭ

(ам.доллар/тонн)




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- Төмрийн хүдэр болон баяжмалын 5 дугаар сарын дуудах дундаж үнэ 67 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 73 ам.доллар болж өсөв.
- Төмрийн төрлөөс хамааран 5 дугаар сард хэлцлийн доод үнэ 56 ам.доллар, дээд үнэ 90 ам.долларт хүрэв.



2024 оны эхний 4 сарын байдлаар төлбөрийн тэнцэл ашигтай гарлаа. Харин 2024 оны 5 дугаар сард гадаад валютын улсын нөөц өмнөх сараас 198 сая ам.доллар буюу 4.0 хувиар өссөн ч төгрөгийн ам.доллартой харьцах ханш өмнөх сараас суларлаа.


ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ (сая ам.доллар)



- Төлбөрийн тэнцэл 2024 оны эхний 4 сард 172 сая ам.долларын ашигтай гарч, ашиг өмнөх оны мөн үеэс 99 сая ам.доллараар буурлаа.
- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 91 сая ам.доллараар нэмэгдсэн ч импортын өсөлт 1 тэрбум ам.долларт хүрснээр урсгал данс алдагдалтай гарлаа.
- Төлбөрийн тэнцлийн шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал* 2024 оны эхний 4 сард 800 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 342 сая ам.доллараар өссөн байна.


*Нийт хөрөнгө оруулалтаас хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгалыг хассан дүн

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ (сая ам.доллар)




- Гадаад валютын улсын нөөц 2024 оны 5 дугаар сарын эцэст 5,183 сая ам.доллар болж, өмнөх сараас 198 сая ам.доллараар, өмнөх оны мөн үеэс 1.3 тэрбум ам.доллараар буюу 33.0 хувиар тус тус өслөө.

ХАНШИЙН ӨДРИЙН ӨӨРЧЛӨЛТ (төгрөг/ам.доллар)



- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2024 оны 5 дугаар сард өдөрт дунджаар 0.1 төгрөгөөр суларч, сарын эцэст 3,381 болж, оны эхнээс 29 төгрөгөөр буюу 0.8 хувиар чангарлаа.

ГАДААД ВАЛЮТЫН ДУУДЛАГА ХУДАЛДАА (сая ам.доллар)



- Төв банк 2024 оны эхний 5 сард нийт 2,454 сая ам.долларыг зах зээлд нийлүүлээ.
- Энэ нь 2023 оны мөн үеэс 90.5 хувиар буюу 1,166 сая ам.доллараар өндөр дүн юм.



Инфляц 2024 оны 5 дугаар сард 5.7 хувьд хүрлээ. Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.7 хувиар өссөн байна.


ЖИЛИЙН ИНФЛЯЦ

(хувь)




САРЫН ИНФЛЯЦ

(хувь)




СУУРЬ ИНФЛЯЦ

(хувь)



ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИНФЛЯЦ

(хувь)



- Инфляц 2024 оны 5 дугаар сард улсын хэмжээнд 5.7 хувьд гарлаа.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 2.0 нэгж хувь (34.7%-ийг бүрдүүлж байна.
- Дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийт инфляцын 3.7 нэгж хувь буюу 65.3 хувийг эзэлж байна.

- 2024 оны 5 дугаар сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.7 хувиар өсөв.
- Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас өсөхөд хүнсний бүлэг 90 хувиар нөлөөлжээ.
- Сарын инфляцад мах, махан бүтээгдэхүүн 86%, талх, гурил, будаа 4%, хүнсний ногоо 8%-ийг тус тус бүрдүүлж байна.

- Суурь инфляц нь нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцсон эрэлтийн гаралтай инфляц юм.
- 2024 оны 5 дугаар сард суурь инфляц 5.4 хувь гарч, нийт инфляцын 3.6 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Суурь инфляц сүүлийн 9 сар дараалан буурч байна.


- Мах, сүү, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт 2024 оны 5 дугаар сард жилийн инфляцын 14 хувийг бүрдүүлж байна.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 15.7 хувиар өсжээ.
- Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ өмнөх оны мөн үеэс 8.8 хувиар өсөв.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 3.7 хувиар өслөө.



Монгол Улсын нэгдсэн төсөв 2024 оны 5 дугаар сарын байдлаар 2.0 их наяд төгрөгийн ашигтай гарлаа. Төсвийн орлого нэмэгдэхэд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар өссөн нь голлон нөлөөллөө.


ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ

(их наяд төгрөг)




ТӨСВИЙН ОРЛОГО

(орлогын эх үүсвэрээр, их наяд төгрөг)




2024 ОНД НЭМЭГДСЭН ГОЛЛОХ ЗАРЛАГУУД

(зарлагын эх үүсвэрээр, их наяд төгрөг)



ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)

(их наяд төгрөг, ДНБ-д эзлэх хувь)




- Нэгдсэн төсөв 2024 оны 5 дугаар сард 2.0 их наяд төгрөгийн ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 632.7 тэрбум төгрөг буюу 45.3 хувиар өссөн байна.
- Орлого 2024 оны 5 дугаар сард 12.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.8 их наяд төгрөг буюу 42.1 хувиар нэмэгдсэн байна.
- Дээрх өсөлтөд орлогын албан татвар 1.5 их наяд төгрөг буюу 70.4 хувиар, АМНАТ 85.8 тэрбум төгрөг буюу 4.5 хувиар, НӨАТ 532.7 тэрбум төгрөг буюу 30.9 хувиар, нийгмийн даатгалын орлого 301.6 тэрбум төгрөг буюу 21.1 хувиар тус тус нэмэгдсэн нь голчлон нөлөөллөө.
- Зарлага 2024 оны 5 дугаар сард 10.0 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 2.9 их наяд төгрөг буюу 41.3 хувиар нэмэгдсэн байна.
- 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс төрийн бүх албан хаагчдын цалинг 10 хувиар, нийтлэг үйлчилгээний ажиллагсдын цалинг 20 хувиар, аллагдсан аймаг, сумд дүүргийн төрийн албан хаагчдын цалин 20-40 хувиар нэмэгдүүлээд байна.
- Засгийн газрын нэрлэсэн өрийн үлдэгдэл 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар 29.8 их наяд төгрөгт хүрч, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа 33.7 хувьд хүрээд байна.
- Засгийн газрын өр (ӨҮЦ)-ийн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.



Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 28.1 хувьд хүрч, өмнөх сараас 2.6 нэгж хувиар өслөө. Төгрөгийн харилцах, хадгаламж, гадаад валютын харилцах өсөлттэй байсан бөгөөд гадаад валютын хадгаламж буурлаа. Зээлийн хүү өмнөх сараас 0.3 нэгж хувиар буурч, өмнөх оны мөн үетэй ижил түвшинд хүрлээ.

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ӨСӨЛТ (жилийн өсөлт, хувь)




Эх сурвалж: Монгол банк

ХАДГАЛАМЖИЙН ӨСӨЛТ (жилийн өсөлт, хувь)




Эх сурвалж: Монгол банк

ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ (хувь)



Эх сурвалж: Монгол банк

ХҮҮГИЙН ТҮВШИН (жигнэсэн дундаж хувь)



Эх сурвалж: Монгол банк

- Мөнгөний нийлүүлэлт 2024 оны 5 дугаар сарын эцэст 39.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 28.1 хувиар өссөн байна.
- Төгрөгийн хадгаламж нийт өсөлтийн 16.0 нэгж хувийг, гадаад валютын харилцах 8,5 нэгж хувийг, төгрөгийн харилцах 5,9 нэгж хувийг, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 0.4 нэгж хувийг гадаад валютын хадгаламж -2.7 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.

- Нийт хадгаламж 23.2 их наяд төгрөгт хүрч хүрч, өмнөх оны мөн үеэс 21.2 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж 18.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 35.2 хувиар, өмнөх сараас 1.0 хувиар тус тус өслөө.
- Гадаад валютын хадгаламж 4.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 16.2 хувиар буурсан бөгөөд өмнөх сараас 0.4 хувиар өслөө.


- Банкнудын зээлийн үлдэгдэл 2024 оны 5 дугаар сарын эцэст 31.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 28.2 хувиар өслөө.
- Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 6.3 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.9 нэгж хувиар буурсан байна.

- Банкнудын зээлийн жигнэсэн дундаж хүү 2024 оны 5 дугаар сард 16.9 хувь болж, өмнөх сараас 0.3 нэгж хувиар буурч, өмнөх оны мөн үетэй ижил түвшинд хүрлээ.
- Банкнудын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2024 оны 5 дугаар сард 11.4 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар өслөө.



Цар тахлын улмаас буураад байсан хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд эдийн засгийн өсөлтийн нөлөөгөөр өсөж, ажиллагчдын тоо 1.3 саяд хүрлээ.

АЖИЛЧДЫН ТОО, ТҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТ (мянган хүн, хувь)




АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН (хувь)



АЖИЛЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ (мянган хүн)



ДУНДАЖ ЦАЛИНГИЙН ӨӨРЧЛӨЛТ (хувь)



- Ажиллагчид өмнөх оны мөн үеэс 182.3 мянгаар нэмэгдэж, 1,293.6 мянгад хүрсэн нь цар тахлын өмнөх үеэс 150.5 мянгаар өндөр үзүүлэлт юм.
- 2024 оны 1 дүгээр улиралд эрэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 129.2 мянгаар нэмэгдсэн бол эмэгтэй ажилчид өмнөх оны мөн үеэс 53.2 мянгаар өссөн үзүүлэлттэй байна.

- Ажиллах хүчний оролцооны түвшин 59.4 хувь болж өссөн ч цар тахлын өмнөх үеэс 0.7 хувиар өндөр байна.
- Ажилгүй иргэдийн тоо 2024 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 5.6 мянган хүнээр буурч, 71 мянгад хүрлээ.
- Ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар буурч, 5.2 хувьд хүрлээ.

- Ажилчдын тоо 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар 1.3 саяд хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 37.8 мянган хүнээр нэмэгдлээ.
- Ажилчдын тооны өсөлтөд, үйлчилгээ ба бусад, худалдаа, тээвэр, барилга, уул уурхай, боловсруулах, ус, цахилгааны салбарын ажилчид эергээр нөлөөлсөн.
- Харин хөдөө аж ахуйн салбарын ажилчид сөргөөр нөлөөллөө.


- Дундаж цалингийн хэмжээ 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 27.7 хувиар өсөж, 2,235 мянган төгрөгт хүрлээ.
- Салбараар авч үзвэл, уул уурхайн салбарын дундаж цалин бусад салбараа тэргүүлж, улсын дунджаас 2.3 дахин өндөр байна.



ОХУ-ын Төв банк мөнгөний бодлогын хүүг 16 хувьд хадгалсан хэвээр байгаа бөгөөд инфляц аажмаар өсөж, зорилтот түвшин 4 хувиас давсан хэвээр байна.

БОДИТ ДНБ-ИЙ ӨСӨЛТ

(хувь)




Эх сурвалж: Блүүмберг

- Дотоодын нийт бүтээгдэхүүн 2024 оны 1 дүгээр улиралд 5.4 хувиар өслөө.
- ОХУ-ын цэргийн армийн зардлын өсөлтөөс шалтгаалсан төсвийн зардал тэлэлт, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотой эдийн засаг 2022 оны 1 дүгээр улирлаас хойш өсөлтэй хэвээр байна.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ

(хувь, өссөн дүнгээр)




Эх сурвалж: Блүүмберг

- Экспорт 2024 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар өсөж, 2022 оны 10 дугаар сараас хойш хамгийн өндөр өсөлтөд хүрлээ.
- Экспортын өсөлтийг газрын тос, байгалийн хийн үнийн өсөлт голчлон дэмжсэн байна.
- Импорт 2024 оны өмнөх оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 18.1 хувиар буурсан байна.
- Импортын бууралтад мөнгөний хатуу бодлого гол нөлөөлөл үзүүлсэн байна.

ИНФЛЯЦ

(хувь)




Эх сурвалж: Блүүмберг

- Инфляцын түвшин 2024 оны 5 дугаар сард нэг жилийн дээд түвшин болох өмнөх сараас 0.5 нэгж хувиар өсөж, 8.3 хувьд хүрлээ.
- Инфляцын түвшин 2023 оны 12 дугаар сараас хойш аажмаар өсөж, Төв банкны зорилтот түвшин 4 хувиас давсан хэвээр байна.

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI) (нэгж)

(нэгж)



Эх сурвалж: Блүүмберг


- Аж үйлдвэрийн салбарын PMI индекс 2024 оны 5 дугаар сард 54.4 болж, өмнөх сарын үзүүлэлтээс 0.9 нэгжээр өсөж, тэллээ.
- Аж үйлдвэрлэлийн бодит өсөлт өмнөх сард үйлдвэрлэл, уул уурхайн салбарын өсөлт удааширсантай холбоотой өмнөх сараас 0.1 нэгжээр буурч, 3.9 нэгжид хүрлээ.



Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2024 оны 5 дугаар сард босго утга 50-аас буурсан ч экспорт 2023 оны 4 дүгээр сараас хойших хамгийн өндөр хурдаар өсөв.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ

(хувь)



Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

- Экспорт 2024 оны 5 дугаар сард өмнөх оноос 7.6 хувиар өссөн нь 2023 оны 4 дүгээр сараас хойших хамгийн өндөр өсөлт боллоо. Үүнд өмнөх оны мөн үед экспорт буурсан суурь үе нөлөөлөв.
- Импортын жилийн өсөлт 2024 оны 5 дугаар сард 1.8 хувьд хүрч, өмнөх сараас буурлаа.

АЖ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЖИЖИГЛЭН ХУДАЛДААНЫ ӨСӨЛТ

(хувь)




Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

- 2024 оны 5 дугаар сард аж үйлдвэрийн гарцын өсөлт 5.6 хувь болж, өмнөх сараас 1.1 нэгж хувиар саарсан бол жижиглэн худалдааны өсөлт өмнөх сараас 1.4 нэгж хувиар өсөж, 3.7 хувьд хүрлээ.

ИНФЛЯЦ

(хувь)




Эх сурвалж: Блүүмберг

- Хэрэглээний үнийн индекс сүүлийн 4 сар дараалан өсөж, 2024 оны 5 дугаар сард өмнөх оноос 0.3 хувиар өслөө.
- Харин үйлдвэрлэгчийн үнийн бууралт сүүлийн 20 сар дараалан үргэлжилж, 2024 оны 5 дугаар сард өмнөх оноос 1.4 хувиар буурлаа.

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI)

(нэгж)



Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2024 оны 5 дугаар сард 49.5 болж, өмнөх сараас 0.9 нэгжээр буурлаа.
- Аж үйлдвэрийн бус салбарын болон нэгдсэн худалдан авалтын менежерийн индексүүд өмнөх сараас мөн өмнөх сараас буурсан ч босго утга 50-аас өндөр хэвээр байна.

Тус индекс нь богино хугацааны идэвхлэлийг илэрхийлэх бөгөөд ААН-үүдийн худалдан авалт, үйлдвэрлэл, ажил эрхлэлт, түүхий эдийн нөөц зэрэг үзүүлэлтийн талаарх аж үйлдвэрийн салбарын 3200 судалгаа, аж үйлдвэрийн бус салбарын 4300 судалгаанд үндэслэн сар бүр тооцдог. Индексийн 50-аас дээш утга нь тэлэлтийг, 50-аас доош нь агшилтыг илэрхийлнэ.



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ